

≡≡≡ ҮЙЛ ЯВДАЛ ≡≡≡

Гавьяат багш цол хүртэв

МУИС-ын ахмад багш нарын нэг, хэл бичгийн ухааны шинжлэх ухааны доктор Г.Гантогтох Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар 2018 оны 7 сарын 8-нд Гавьяат багш цол хүртэв.


Г.Гантогтох багш 1949 онд Дорнод аймгийн Дашбалбар суманд мэндэлсэн бөгөөд 1957-1967 онд Дорнод аймгийн Чойбалсан хотын 10 жилийн дунд сургууль, 1967-1971 онд УБДС (тухайн үеийн нэрээр)-ийн Монгол хэл-утга зохиолын ангид суралцаж төгсжээ. Улмаар 1971-1975 онд төрөлх УБДС-ийн монгол хэл, уран зохиолын тэнхимд багш, 1975-1992 онд ШУА-ийн ХЗХ-д эрдэм шинжилгээний ажилтан, 1992-2015 он хүртэл МУИС-д багшаар тус тус ажилласан түүхтэй. Тэрбээр 1993 онд хэл бичгийн ухааны дэд эрдэмтэн, 2006 онд шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан байна. Тэрбээр оюутан, магистрант, докторантын суралцагсад монгол хэлний авиазүй, монгол хэлний нутгийн аялгуу судлал, үсэгзүй, хэл бичгийн ухаан зэрэг хичээл зааж байв.

Г.Гантогтох багш сургалтын үйл ажиллагаанд идэвхтэй оролцохын зэрэгцээ эрдэм шинжилгээний 10 гаруй ном, 70 орчим өгүүлэл туурвиж хэвлэн нийтлүүлжээ. Тухайлбал “БНМАУ-ын нутгийн аялгууны толь бичиг” (1988), “Монгол үсгийн зурлагыг салгасан бичиг” (1992, 1995), “Буриад аялгууны үгийн сангийн бүрэлдэхүүний онцлог” (1993), “Монгол бичиг - IV ангийн сурах бичиг” (1999), “Монгол хэлний нутгийн аялгуу” (2001), “Бөө мөргөлийг сэнхрүүлэн бадруулахын учир” (2004), “Монгол зан үйлийн аман яруу найргийн уламжлал” (2006), “Буриад аялгууны толь” (2011), “Монгол нүүдэлчдийн тайлбар толь” (2014) зэрэг бүтээлийг дурдаж болно. Мөн монгол бичиг, монгол хэл шинжлэл, бөө мөргөлийн үг хэллэг, зан үйл судлал, нутгийн аялгуу судлал, хэл-соёл-зан үйл судлалын чиглэлээр бичсэн өгүүллүүд нь “МУИС-ын профессорын эрдмийн өв” цувралд 2 ботиор хэвлэгдсэн билээ.

* * *

Номын нээлт болов

МУИС-ын Монгол судлалын хүрээлэнгээс эрхлэн гаргадаг “МУИС-ын профессорын эрдмийн өв” цувралаар Монгол Улсын Гавьяат багш, хэл бичгийн шинжлэх ухааны доктор, профессор Г.Гантогтохын эрдэм шинжилгээний өгүүллийн чуулганыг 2 ботиор хэвлэн нийтэлжээ. Тус эмхэтгэлийн 1-р ботид монгол хэл аялгуу, үсэг бичгийн судлалын чиглэлээр туурвисан өгүүлүүд, 2-р ботид угсаа хэл шинжлэл, сурвалж бичиг, бөө мөргөлийн үг хэллэгийн талаарх өгүүлүүдийг нь оруулсан байна.



Мөн Монгол Улсын Ардын багш С.Дуламын эрдэм шинжилгээний өгүүллийн чуулган 3 ботийг мөн Домог зүй, бөө мөргөлийн судалгаа (I боть), Монгол аман зохиол, харьцуулсан аман зохиолын судалгаа (II боть), Монгол уран зохиол судалгаа, орчуулгын онол (III

боть) гэсэн ботиор хэвлэн нийтэлсэн ба тус бүтээлийн чуулганы нээлтийг 2018 оны 12 сарын 26-д хийж олон нийтэд түгээсэн билээ. Мөн тус бүтээлүүдийн үргэлжлэл соёл, урлаг судлалын сан хөмрөг гурван боть “Соёл, урлагийн судалгаа” (IV боть), “Бэлгэдэл зүйн судалгаа” (V боть), “Бурханы шашин, нийгэм, хэл шинжлэлийн судалгаа” (VI боть) бүтээлүүд хэвлэгдэн гарчээ.



* * *